МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ • АЖЛЫН ТАЙЛАН

УИХ-ЫН ГИШҮҮН Д.БУМ-ОЧИР

Ажлын хэсэг, Байнгын хороод, хууль тогтоох & хянан шалгах үйл ажиллагаа

2024–2026

БҮРЭН ЭРХИЙН ХУГАЦАА

8	5	13
АЖЛЫН ХЭСЭГ	БАЙНГЫН ХОРОО	ХУУЛИЙН ТӨСӨЛ



★ АХЛАН АЖИЛЛАСАН АЖЛЫН ХЭСЭГ | ТОГТООЛ №03 (2025.01.14)

Инновац, цахим бодлогын байнгын хорооны даргын 2025 оны 01 сарын 14-ний өдрийн 03 дугаар тогтоолоор “Хилийн чанад дахь Монгол иргэдэд төрийн үйлчилгээний нэгдсэн И-Монгол цахим системийг хүртээмжтэй болгох, цахимаар сонгуульд оролцох эрхийг хангах боломжийг судлах санал, дүгнэлт гаргах үүрэг бүхий ажлын хэсэг”-ийг ахлан ажилласан.

· Чиг үүрэг: Хилийн чанадад оршин суугаа Монгол Улсын иргэдийн сонгох эрхийг цахимаар хангах техник, эрх зүйн боломж болон E-Mongolia платформыг гадаад дахь иргэдэд хүндрэлгүй, хүртээмжтэй хүргэх цогц санал, дүгнэлтийн төсөл боловсруулах.

• 2026.05.29 / Захирамж №231

УИХ-ын гишүүний ёс зүйн дүрэмд нэмэлт, өөрчлөлт оруулах ажлын хэсэг

Парламентын гишүүний ёс зүй, хариуцлагын механизмыг олон улсын жишигт нийцүүлэн шинэчлэх, сахилга хариуцлагын эрх зүйн орчныг боловсронгуй болгох төсөл боловсруулах.

• 2026.11.03 / Захирамж №11

Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл

Нө Нийгмийн сүлжээнд хүүхдийн оролцоог зохицуулах тухай хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг

• 2025.04.22 / Захирамж №185

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн уялдаа & мониторингийн тогтолцооны ажлын хэсэг

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгүүдийн уялдааг хангах, шалгуур үзүүлэлтийг оновчлох, үр дүнд суурилсан үнэлгээ, мониторингийн эрх зүйн орчныг бүрдүүлэх.

• 2025.02.26 / Захирамж №104

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах анхдагч хуулийн төслийн ажлын хэсэг

ТӨК-ийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах анхдагч хуулийн төслийг Байнгын хороо болон чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх санал, дүгнэлт боловсруулах.

• 2025.08.06 / Захирамж №323

Төрийн болон орон нутгийн өмчит компанийн бүтээмж, ил тод байдал, засаглалыг сайжруулах тухай анхдагч хуулийн төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын тогтоолын төсөл, Нийтийн өмчийн хуулийн шинэчилсэн найруулгын төслүүдийг хэлэлцүүлэгт бэлтгэх, санал дүгнэлт гаргах ажлын хэсэг

Хүний эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний талаар судалгаа хийж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах.

• 2024.09.05 / Захирамж №114

Боловсролын хуулийн хэрэгжилт, багшийн хомсдол, менежментийн ажлын хэсэг

Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилттэй танилцаж, бүх шатны сургуулийн багшийн хомсдолыг бууруулах, үнэлэмжийг дээшлүүлэх, менежментийг сайжруулах санал, дүгнэлт гаргах.

• 2024.09.05 / Захирамж №89

Ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээ, хуулийн төслийн ажлын хэсэг

Хүний эрхийг хангах, ялгаварлан гадуурхалтын эсрэг авах арга хэмжээний талаар судалгаа хийж санал, дүгнэлт гаргах, шаардлагатай бол хуулийн төсөл боловсруулах.



[2024 – 2025 он] Байгаль орчин, хүнс, хөдөө аж ахуйн байнгын хороо

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, хүнсний аюулгүй байдлыг хангах, мал аж ахуй, газар тариалангийн эрх зүйн орчныг сайжруулахад чиглэсэн бодлогын хэлэлцүүлгүүдэд идэвхтэй ажиллав.

[2024 – 2025 он] Боловсрол, соёл, шинжлэх ухаан, спортын байнгын хороо

Боловсролын багц хуулийн хэрэгжилт, их дээд сургуулийн засаглал, соёлын өвийг хамгаалах болон шинжлэх ухааны салбарын төсөв, бүтцийн шинэчлэлд санал өгч ажиллав.

[2025 оноос хойш] Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо

Монгол Улсын үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал, олон улсын гэрээ, хэлэлцээр, хилийн чанад дахь иргэдийн эрх ашиг, гадаад харилцааны бодлогын чиглэлээр ажиллаж байна.

[2025 оноос хойш] Хүний хөгжил, нийгмийн бодлогын байнгын хороо

Хүний эрхийг хамгаалах, эрүүл мэнд, нийгмийн даатгал, халамжийн шинэчлэл, нийгмийн эмзэг бүлгийн хамгааллыг чангатгах асуудлуудыг хариуцан ажиллаж байна.

[2025 оноос хойш] Боловсрол, шинжлэх ухааны дэд хороо

Эрдэм шинжилгээ, сургалт үйлдвэрлэлийн уялдааг сайжруулах, их сургуулиудын эрдэм шинжилгээний чадавх, эрдэмтэн судлаачдын үнэлэмжийг дэмжих чиглэлээр дэд хороонд ажиллаж байна.





АЙМАГ, НИЙСЛЭЛ, СУМ, ДҮҮРГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ӨРГӨН МЭДҮҮЛЛЭЭ

[2026.04.20 (2026.04.21) ӨРГӨН МЭДҮҮЛСЭН] Аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ-ын сонгуулийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (Санаачлагч: Д.Бум-Очир)

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын сонгуулийн тухай хуулийн 47.7 дахь хэсэгт 'Орон нутгийн Хурлын төлөөлөгч' гэж байгааг 'аливаа этгээд' гэж өөрчлөн найруулж, нэр дэвших ажиллагаа эхлэхээс өмнө тойргийн сонгогчдодоо ажлын тайлангаа танилцуулах зорилгоор хийсэн уулзалт, тус хуулиар хориглоогүй арга хэмжээ болон тараасан тайлан нь сонгуулийн сурталчилгаанд хамаарахгүй байх зохицуулалтыг тусгалаа.

• Үр дүн & Ач холбогдол: Монгол Улсын Үндсэн хуульд заасан 'хүн бүр хуулийн өмнө эрх тэгш байх, эрхэлсэн ажил албан тушаалаар нь ялгаварлан гадуурхаж болохгүй' зарчим бүрэн хангагдана.

Хуулийн төсөл батлагдсанаар:

Монгол Улсын Үндсэн хуульд заасан хүн бүр хуулийн өмнө **ЭРХ ТЭГШ БАЙХ, ХҮНИЙГ ЭРХЭЛСЭН АЖИЛ, АЛБАН ТУШААЛААР НЬ ЯЛГАВАРЛАН ГАДУУРХАЖ БОЛОХГҮЙ** гэсэн зарчим хангагдана.

Өргөн мэдүүлсэн огноо:

2026.04.21

Хуулийн төсөл санаачлагч:




УИХ-ын гишүүн
Д.БУМ-ОЧИР

Хуулийн төслийн ач холбогдол:

Нэр дэвшүүлэх ажиллагаа эхлэхээс өмнө аливаа этгээдийн ажлын тайлангаа танилцуулахаар зохион байгуулсан уулзалт, хуулиар хориглоогүй арга хэмжээ нь сонгогчдын санал татах зорилгоор явуулж байгаа үйл ажиллагаанд хамаарахгүй.

[2026.05.14 ӨРГӨН МЭДҮҮЛСЭН] Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (Санаачлагч: Д.Бум-Очир)

Хуулийн төслөөр 3 гол зохицуулалтыг шийдвэрлэв:
1. Сонгогч өөрийн харьяа бус өөр нутаг дэвсгэрт байгаа үед саналыг нь авах зохион байгуулалтыг бүрдүүлснээр 'царцааны нүүдэл' хязгаарлагдаж, хумигдана.
2. Санал авах өдөр биечлэн очих боломжгүй иргэдийн саналыг урьдчилан авах төрөл, эрх зүйн орчныг бүрдүүлсэн.
3. Гадаад улсад байгаа иргэд урьдчилан бүртгүүлэхгүйгээр санал өгөх боломжийг бүрдүүлж, санал авах байрыг нэмэгдүүлэн, явуулын хайрцаг ажиллуулахаар тусгав.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН СОНГУУЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ ӨРГӨН МЭДҮҮЛЭВ

Төсөл санаачлагч:



УИХ-ын гишүүн
Д.БУМ-ОЧИР



УИХ-ын гишүүн
Ч.АНАР



УИХ-ын гишүүн
Ж.БАЯРМАА



УИХ-ын гишүүн
Ж.ЗОЛЖАРГАЛ

Өргөн мэдүүлсэн огноо:
2026.05.14

Төслийн ач холбогдол:

- Хөдөө орон нутагт ажиллаж байгаа иргэд, эсвэл хотод сурч байгаа оюутнууд тухайн газартаа саналаа өгөхөд **өөрийнх нь албан ёсны бүртгэлтэй хаяг** дээрээс санал нь шууд бүртгэгдэнэ.
- Орон нутаг, гадаадад ажиллахаар явж буй иргэд сонгуулийн албан ёсны **санал хураалт болохоос өмнө** урьдчилж санал өгөх боломжтой болно.
- Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэд хоёр өдрийн дотор санал өгдөг байсныг **нэмж 5 өдөр** болгоно.
- Санал авах өдөр тухайн сонгогчийн харьяа хэсгийн хороо хамаарах аймаг, нийслэлээс өөр нутаг дэвсгэрт байгаа сонгогчийн саналыг авах, түүнд шаардлагатай зохион байгуулалтын арга хэмжээ авах **эрх зүйн орчныг** бүрдүүлнэ.

Төсөл батлагдсанаар:

- **Сонгуулийн үндсэн зарчмын нэг болох бүх нийтийн байх, оролцоог бүрэн хангах нөхцөлийг бүрдүүлнэ гэж хууль санаачлагчид үзсэн.**





БОЛОВСРУУЛЖ БУЙ & ХАМТРАН ӨРГӨН МЭДҮҮЛСЭН БУСАД ХУУЛЬ, ТОГТООЛУУД

[Бие даан боловсруулж буй] Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай анхдагч хуулийн төсөл (Боловсруулж буй)	**[Бие даан боловсруулж буй]** Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (Боловсруулж буй)
[Бие даан боловсруулж буй] Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл, 2026 оны 04 сарын 21-нд өргөн мэдүүлсэн.	**[Бие даан боловсруулж буй]** Монгол Улсын Ерөнхийлөгчийн сонгуулийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл, 2026 оны 05 сарын 14-нд өргөн мэдүүлсэн.
[Хамтран өргөн мэдүүлсэн] Үндэсний их баяр наадмын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2025.11.27) (Санаачлагч: УИХ-ын гишүүн О.Амгаланбаатар)	**[Хамтран өргөн мэдүүлсэн]** Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд нэмэлт оруулах тухай (2025.11.14) (Санаачлагч: УИХ-ын гишүүн М.Бадамсүрэн)
[Хамтран өргөн мэдүүлсэн] Хүнсний бүтээгдэхүүний аюулгүй байдлыг хангах тухай хуульд нэмэлт оруулах тухай (2025.07.04) (Санаачлагч: УИХ-ын гишүүн С.Лүндэг)	**[Хамтран өргөн мэдүүлсэн]** Үндэсний их баяр наадмын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2025.06.23) (Санаачлагч: Б.Жаргалан)
[Хамтран өргөн мэдүүлсэн] Ялгаварлан гадуурхалт, дарамтаас ангид байх, урьдчилан сэргийлэх тухай хуулийн төсөл (Санаачлагч: УИХ-ын гишүүн О.Саранчулуун)	**[Хамтран өргөн мэдүүлсэн]** Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2026.09.29) (Санаачлагч: С.Цэнгүүн)
[Хамтран өргөн мэдүүлсэн] Хувь хүний орлогын албан татварын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай (2026.03.30) (Санаачлагч: УИХ-ын гишүүн Ж.Баярмаа)	**[Хамтран өргөн мэдүүлсэн]** Эмнэлгийн тусламж, үйлчилгээний тухай хуулийн шинэчилсэн найруулга (2026.05.29) (Санаачлагч: УИХ-ын гишүүн Д.Ганмаа)
[Хамтран өргөн мэдүүлсэн] Төсвийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай (2026.09.28) (Санаачлагч: УИХ-ын гишүүн С.Цэнгүүн)	**[Хянан шалгах түр хороо]** Эрүүл мэндийн салбарын стратегийн худалдан авалт, санхүүжилтийг шалгах Түр хороо (2025.11.24) (Санаачлагч: УИХ-ын гишүүн Д.Ганмаа)
[Хянан шалгах түр хороо] Гашуунсухайт-Ганцмод боомтын төмөр замын хэлэлцээрт хяналт шалгалт хийх Түр хороо (2025.10.10) (Санаачлагч: УИХ-ын гишүүн Ж.Баярмаа)	**[Хянан шалгах түр хороо]** Хүүхэд хамгааллын тогтолцооны үр нөлөө, салбар хоорондын уялдааг шалгах Түр хороо (2026.05.05) (Санаачлагч: УИХ-ын гишүүн Х.Баасанжаргал)



[2024.10.01 & 2024.11.18 | УИХ-ЫН 114 ДҮГЭЭР ЗАХИРАМЖ] Боловсролын ерөнхий хуулийн хэрэгжилт ба МУБИС-ийн үйл ажиллагаа

Багшийн хомсдолыг шийдвэрлэх ажлын хэсэг (Ахлагч Ж.Галбадрах, гишүүн Д.Бум-Очир нар) МУБИС дээр газар дээр нь ажиллав. МУБИС-ийн 11,212 оюутан, багшийн хомсдолын 2030 он хүртэлх тооцоолол, 3,818 оюутны 9.4 тэрбум төгрөгийн тэтгэлгийн гүйцэтгэлийг хэлэлцэж, бодлогын арга хэмжээ авч ажиллахаар тохиролцов.



[SDY JUNIOR CLUB] “LET’S GO GEN Z: IDENTITY MATTERS” арга хэмжээнд илтгэл тавив (2025.05.26)

“Identity matters” арга хэмжээнд оролцож, залууст 'Монгол үндэстний ондоошил, үнэт зүйл, онцлог, даяаршлын нөлөө' сэдвээр илтгэл танилцуулж, урлаг, соёл, малчдын төлөөлөлтэй хамт соёлын дархлааны сэдвээр ярилцлаа.





[NEW NOMAD INSTITUTE & CREATIVE MORNINGS] “2025 оны Нүүдэлчин гэж хэн бэ?” олон улсын хэлэлцүүлэг (2025.08.11)

Нью Номад институтээс зохион байгуулсан хэлэлцүүлэгт оролцож, Нүүдэлчин гэх тодорхойлолт, нүүдлийн соёл болон англи хэлний 'nomad, nomadism, nomadic civilization' ойлголтуудын ялгаатай байдлын талаар танилцуулж, нүүдлийн соёл иргэншлийн өнөөгийн үнэ цэнийг тайлбарлав.



[РОЯАЛЬ ОЛОН УЛСЫН ИХ СУРГУУЛЬ] Магистрын сургалтын нээлтийн хүндэтгэлийн лекц (2026.04.07)

2025–2026 оны хичээлийн жилийн магистрантуудад зориулан 'Монголын ёс суртахууны онцлог ба өвөрмөц шинж чанар' (Moral Characteristics and Distinctive Features of Mongolia) сэдвээр илтгэл хэлэлцүүлэв.





[2026.02.05 | ХХААХҮЯ & FAO] “Бэлчээр ба нүүдлийн мал аж ахуй эрхлэгчдийн олон улсын жил – 2026” үндэсний нээлт (2026.02.12)

НҮБ-ын ХХААБ, төрийн болон олон улсын 150 гаруй төлөөлөгчид оролцсон нээлтэд оролцож, НҮБ-ын Цөлжилттэй тэмцэх конвенцын COP17 бага хуралтай бэлчээрийн бодлогыг уялдуулах илтгэл танилцууллаа.



[ГОВИЙН БҮСИЙН МАЛЧДЫН УУЛЗАЛТ] Уул уурхайн нөлөөлөлд өртөж буй малчдын эрх ашиг & Нийгэм-соёлын нөлөөллийн үнэлгээний хууль (2026.04.08)


Уул уурхайн нөлөөллийн бүсэд амьдарч буй малчдын тулгамдсан асуудлыг шинжлэх ухааны үндэслэлтэй судалж, бодлого, хууль эрх зүйн түвшинд шийдвэрлэх шаардлагатайг онцлон ярилцав. Мөн нүүдэлчин соёл, уламжлалыг олон улсын түвшинд хамгаалж, ЮНЕСКО-гийн хүрээнд баталгаажуулах боломжийн талаар санал солилцлоо.

Малчны ахуй, нүүдэлчдийн соёлыг хамгаалах, ЮНЕСКО-д баталгаажуулах болон өөрийн санаачлан боловсруулж буй 'Нийгэм-соёлын нөлөөллийн үнэлгээний тухай хууль'-ийн төслийг малчдад танилцуулж, уул уурхайн төслүүдийн соёл, байгаль орчны нөлөөллийг бодитоор үнэлэх гарцыг хэлэлцэв.



[ШИНЖЛЭХ УХААНЫ САЛБАРЫН АЖИЛ] Мал эмнэлгийн хүрээлэн & МУИС-ийн Шинжлэх ухаан, технологийн Улаанбаатар парк (ШУТУБП) (2026.02.12)

Эрдэм шинжилгээний хүрээлэнгүүдийн лаборатори, судалгааны үр дүнг эдийн засгийн эргэлтэд оруулах, малын эмийн үйлдвэр байгуулах болон их сургуулийн инновацын экосистемийг бодлогоор дэмжих асуудлаар газар дээр нь ажиллав.





[2026.05.20 & COP17] “Нийгэмд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль”-ийн хэлэлцүүлэг ба COP17 олон улсын хурал (2026.08.22)

МУИС-ийн номын санд эрдэмтэн, судлаачдын дунд хуулийн төслийн нээлттэй хэлэлцүүлэг зохион байгуулав. Мөн COP17-ийн хүрээнд Олон улсын эрх зүйн хөгжлийн байгууллага (IDLO), Оксфордын их сургуультай хамтран 'Бэлчээрийн эрхийг хангахад нийгмийн нөлөөллийг үнэлэх нь' хурлыг амжилттай зохион байгуулж өөрийн санаачилсан хуулийн үзэл баримтлалыг танилцууллаа.



